



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/76/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261665 Цахим хаяг: [Naranchimegts@audit.gov.mn](mailto:Naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: В.Эрдэнэцогт

Утас: 260512 Цахим хаяг: [Erdenetsogtv@audit.gov.mn](mailto:Erdenetsogtv@audit.gov.mn)

Аудитор: Б.Отгонцэцэг

Утас: 261740 Цахим хаяг: [Otgontsetsegb@audit.gov.mn](mailto:Otgontsetsegb@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК

Захирал: Ч.Энхтуяа

Цахим хаяг: [enkhtuya@hlb.mn](mailto:enkhtuya@hlb.mn)

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн Газар
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
ООТА	Орлогыг орлуулан тооцох аргачлал
ӨМНС	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан
СЯ	Сангийн Яам
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Х.АСЫЛ ТАНАА

2026.04.13 № 06/1051  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2"-ыг хэрэгжүүлэхэд Азийн Хөгжлийн Банкны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжигдэх 46,400.0 мянган ам.долларын 4052-МОН дугаартай энгийн зээл, 26,600.0 мянган ам.долларын 4051-МОН дугаартай хөнгөлөлттэй зээлүүдийг олгохоор болсон байна.

Төслийн нийт санхүүжилтийн хэмжээ 259,640.0 мянган ам.доллар бөгөөд АХБ-ны санхүүжилт 73,000.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн газрын санхүүжилт 186,640.0 мянган ам.доллар байна. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр дээрх зээлийг соёрхон баталсан бөгөөд төсөл 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжиж дууссан.

### Аудитын гол асуудал

Азийн Хөгжлийн Банкны зээлийн хөрөнгөөр тус төслийн хүрээнд Нийгмийн халамжийн хөтөлбөрийн цахимжуулалтад зориулсан мэдээллийн сангийн тоног

төхөөрөмж, программ хангамж худалдан авахад 1,582,159.5 мянган төгрөг, Сервер, компьютерын хүчин чадал нэмэгдүүлэх төхөөрөмж нийлүүлэхэд 226.2 мянган төгрөг, нийт 1,808,366.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн. Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрт хамрагдаж байгаа зорилтот өрхүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэх болон нийгмийн хамгааллын системийг бэхжүүлэхэд зориулж тайлант онд 802,813.6 мянган төгрөг, өрхийн ур чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн ажилтан болон халамжийн ажилчдыг чадавхжуулах ажлын хүрээнд сургалтад 465,175.6 мянган төгрөг, хэвлэл мэдээлэлд 101,532.3 мянган төгрөг, халамжийн үйлчилгээний цахимжуулалт болон бусад ажилд 435,514.8 мянган төгрөг, нийт 1,805,036.3 мянган төгрөгийн ажлыг зохион байгуулсан байна.

Төсөл нь 2025 ондоо амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд нийт санхүүжилтээс 581,377.6 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь 2025 онд 3,210,082.8 мянган төгрөгийн гадаад зээлийн санхүүжилт авч, Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэх, Халамжийн цахим системийг хөгжүүлэх, Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт (АДБОУС) -ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,233,705,368.37</b>	<b>641,260,063.81</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,176,557,262.10</b>	<b>581,377,593.94</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,176,557,262.10</b>	<b>581,377,593.94</b>
31210	Төгрөг	544,603,586.63	80,000.00
31211	Төрийн сангийн харилцах	544,603,586.63	80,000.00
31220	Гадаад валют	631,953,675.47	581,297,593.94
31221	Төрийн сангийн харилцах	631,953,675.47	581,297,593.94
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,000.00</b>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,000.00	-
33103	Татварын авлага	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
34600	Урьдчилж гарсан зардал	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>8,630,379.00</b>	<b>8,630,379.00</b>
35400	Хангамжийн материал	8,630,379.00	8,630,379.00
35420	Аж ахуйн материал	8,630,379.00	8,630,379.00
<b>36</b>	<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>48,515,727.27</b>	<b>51,252,090.87</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	48,515,727.27	51,252,090.87
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,233,705,368.37</b>	<b>641,260,063.81</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,000.00</b>	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,000.00	-
41360	Бусад өглөг	-	-
41363	Татварын өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,233,703,368.37</b>	<b>641,260,063.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,233,703,368.37</b>	<b>641,260,063.81</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,233,703,368.37</b>	<b>641,260,063.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,574,739,765.85	1,233,703,367.37
51220	Тайлант үеийн үр дүн	(1,341,036,397.48)	(592,443,304.56)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,233,705,368.37</b>	<b>641,260,063.81</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,341,976,364.56</b>	<b>3,210,682,788.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,341,976,364.56</b>	<b>3,210,682,788.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,341,976,364.56</b>	<b>3,210,682,788.09</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,341,976,364.56</b>	<b>3,210,682,788.09</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,264,062,064.56	3,210,082,788.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,714,300.00	-
120009	Бусад орлого	200,000.00	600,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,682,944,145.89</b>	<b>3,820,354,543.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,682,944,145.89</b>	<b>3,820,354,543.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,682,944,145.89</b>	<b>3,820,354,543.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>253,115,072.35</b>	<b>160,446,293.10</b>
210101	Үндсэн цалин	253,115,072.35	160,446,293.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,639,384.04</b>	<b>20,055,786.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,639,384.04	20,055,786.64
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,813,808.94</b>	<b>2,882,166.67</b>
210401	Бичиг хэрэг	879,400.00	1,307,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,934,408.94	1,575,166.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>840,000.00</b>	<b>860,000.00</b>
210604	Урсгал засвар	840,000.00	860,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>250,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод томилолт зардал	250,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,392,285,880.56</b>	<b>1,827,743,937.33</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,375,615,921.56	1,797,954,601.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	29,700,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	169,959.00	89,336.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээс</b>	<b>-</b>	<b>1,808,366,360.00</b>
225012	Тоног төхөөрөмж	-	1,808,366,360.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(1,340,967,781.33)</b>	<b>(609,671,755.65)</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>7,322,056.23</b>	<b>29,917,502.16</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,322,056.23	29,917,502.16
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,390,672.38</b>	<b>12,689,51.07</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	7,263,636.40
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	7,390,672.38	5,425,414.67
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(1,341,036,397.48)</b>	<b>(592,443,304.56)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,264,174,021.45</b>	<b>705,770,113.59</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,264,174,021.45</b>	<b>705,770,113.59</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,264,174,021.45</b>	<b>705,770,113.59</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,263,974,021.45</b>	<b>705,770,113.59</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,263,974,021.45	705,074,780.26
1200047	Бусад орлого	200,000.00	695,333.33
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,594,422,439.89</b>	<b>1,099,165,957.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,594,422,439.89</b>	<b>1,099,165,957.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,594,422,439.89</b>	<b>1,099,165,957.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>253,115,072.35</b>	<b>127,873,472.45</b>
210101	Үндсэн цалин	253,115,072.35	127,873,472.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,639,384.04</b>	<b>52,965,711.09</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,639,384.04	52,965,711.09
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,813,808.94</b>	<b>12,882,166.67</b>
210401	Бичиг хэрэг	879,400.00	1,307,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,934,408.94	1,575,166.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	10,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>840,000.00</b>	<b>860,000.00</b>
210604	Урсгал засвар	840,000.00	860,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>250,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	250,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,303,764,174.56</b>	<b>904,584,607.36</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,287,264,174.56	874,884,607.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	29,700,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,330,248,418.45)</b>	<b>(393,395,843.98)</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>-</b>	<b>226,206,860.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>226,206,860.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>226,206,860.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	226,206,860.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-	<b>(226,206,860.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(150,532.03)</b>	<b>24,423,035.82</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>7,254,667.77</b>	<b>29,848,450.49</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	7,254,667.77	29,848,450.49
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>7,405,199.80</b>	<b>5,425,414.67</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	7,405,199.80	5,425,414.67
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,330,398,950.48</b>	<b>(595,179,668.16)</b>
<b>101</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,506,956,212.58</b>	<b>1,176,557,262.10</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,176,557,262.10</b>	<b>581,377,593.94</b>
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,574,739,765.85</b>	<b>2,574,739,765.85</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,574,739,765.85	2,574,739,765.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,341,036,397.48)	(1,341,036,397.48)
<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	-	-	<b>1,233,703,368.37</b>	<b>1,233,703,368.37</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,233,703,368.37	1,233,703,368.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(592,443,304.56)	(592,443,304.56)
<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	-	-	<b>641,260,063.81</b>	<b>641,260,063.81</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,238,225,000.00</b>	<b>3,829,665,207.74</b>	<b>408,559,792.26</b>	<b>90.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,428,225,000.00</b>	<b>2,021,298,847.74</b>	<b>406,926,152.26</b>	<b>83.2</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,428,225,000.00</b>	<b>2,021,298,847.74</b>	<b>406,926,152.26</b>	<b>83.2</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>245,000,000.00</b>	<b>160,446,293.10</b>	<b>84,553,706.90</b>	<b>65.5</b>
Үндсэн цалин	245,000,000.00	160,446,293.10	84,553,706.90	65.5
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,625,000.00</b>	<b>20,055,786.64</b>	<b>10,569,213.36</b>	<b>65.5</b>
Тэтгэврийн даатгал	30,625,000.00	20,055,786.64	10,569,213.36	65.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,340,000.00</b>	<b>2,282,166.67</b>	<b>3,057,833.33</b>	<b>42.7</b>
Бичиг хэрэг	1,340,000.00	1,307,000.00	33,000.00	97.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	1,575,166.67	2,424,833.33	39.4
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>860,000.00</b>	<b>860,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Урсгал засвар	860,000.00	860,000.00	-	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Дотоод томилолт	-	-	-	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,146,400,000.00</b>	<b>1,827,654,601.33</b>	<b>318,745,398.67</b>	<b>85.1</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,116,700,000.00	1,797,954,601.33	318,745,398.67	84.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,700,000.00	29,700,000.00	-	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,810,000,000.00</b>	<b>1,808,366,360.00</b>	<b>1,633,640.00</b>	<b>100.0</b>
Тоног төхөөрөмж	1,810,000,000.00	1,808,366,360.00	1,633,640.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,238,225,000.00</b>	<b>3,210,682,788.09</b>	<b>1,027,542,211.91</b>	<b>75.8</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,238,225,000.00	3,210,682,788.09	1,027,542,211.91	75.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,176,557,262.10		
Төсвийн тохируулга		24,423,035.82		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		581,377,593.94		
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	5	4	1	80.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4	3	1	75.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банкны хооронд 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан ердийн болон хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээний дагуу Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2 нь 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжинэ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/1772 дугаартай Төслийн дуусгавар болох хугацааг сунгах тухай албан бичиг болон Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/4787 тоот дугаартай Төслийн дуусгавар болох хугацааг сунгах тухай албан бичиг, Азийн Хөгжлийн Банкны 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдөр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн төслийн дуусгавар болох хугацааг 1 жилээр буюу 2025 оны 08 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаанд сунгасан.

Төслийн гол зорилго нь: Цар тахлын үед зорилтот бүлгийн хүн ам, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулахад чиглэнэ.

Тус төсөл нь 2021-2025 оны хооронд дараах зорилтуудыг баримталж ажиллана. Үүнд:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийг олгох /2021 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд нэмэлтээр сар бүр олгох хүүхдийн тэтгэмжийн нэмэлт хувийг санхүүжүүлэх/
- Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэх /Зорилтот бүлгийг тогтоох систем болон өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчилж, сайжруулах, Нийгмийн халамжийн хөтөлбөрийг “ehalamj” системд цахимжуулах ажлыг дэмжих, Төгсөлтийн аргачлалыг нийгмийн хамгааллын тогтолцоонд туршиж, үнэлэх/

Тус төсөл нь 2025 онд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийг олгох ажил 100 хувь, Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны 01 сарын 03-ний өдрийн А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ын журам”;

“Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны санхүүгийн тайланг, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ний өдөр А/З дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 592,445.2 мянган төгрөгөөр буюу 48.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,176,557.2	581,377.6	(595,179.6)
Авлага	2.0	-	(2.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	8,630.4	8,630.4	(0.0)
Бусад эргэлтийн хөрөнгө	48,515.7	51,252.1	2,736.4
Нийт хөрөнгө	1,233,705.3	641,260.1	(592,445.2)
Өр төлбөр	2.0	-	(2.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,233,703.3	641,260.1	(592,443.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,233,705.3	641,260.1	(592,445.2)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 581,377.6 мянган төгрөг болж 595,179.00 мянган төгрөгөөр буурсан нь гадаад эх үүсвэрээс төрийн сангийн харилцах дансаар 705,074.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч урсгал зардалд 1,099,165.9 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд 226,206.9 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэлд төгсөлтийн аргачлалын хөтөлбөрийн хүрээнд хийж буй өрхийн хяналт, өрхийн ахицын мэдээллийг цуглуулан дижитал хяналтын системд бүртгэх ажилд ашиглах зориулалттай таблет, нөүтбүүк 51,252.7 мянган төгрөгийн бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 641,260.1 мянган төгрөгт хүрч, 592,445.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлээс 4,238,225.0 мянган төгрөгөөр тооцож, үүнээс урсгал зардалд 2,428,225.0 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 1,810,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төслөөс хэрэгжүүлж буй 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр гадаад зээлийн эх үүсвэрээс 3.210,082.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,325,372.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс цалингийн зардалд 180,502.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 860.0 мянган төгрөг, хангамжийн зардалд 2,882.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 1,797,954.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Төслийн нийт зардал 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70207	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	4,238,225.0	3,210,682.8	1,027,542.2	76.0
2	80104	Үйл ажиллагааны зардал	4,238,225.0	3,829,665.2	408,559.7	90.0
3	80918	Хөрөнгийн зардал	1,810,000.0	1,808,366.3	1,633.6	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл нь COVID-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой. Хүлээгдэж буй үр дүн нь ядуу болон эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн хамгааллын дэмжлэгийг сайжруулах явдал юм.

Төсөл нь хоёр гаралттай:

- (1) Ядуу өрхөд чиглэсэн хүүхдийн мөнгөний нэмэгдлийг олгох,
- (2) Нийгмийн хамгааллын хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэх.

Төслийн зорилго, үр дүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэрэгжилтийг хянах системийг ашигладаг бөгөөд уг хяналтын системд тусгагдсан хоёр үр дүнгийн үзүүлэлт болон дөрвөн гаралтын үзүүлэлт бүгд хэрэгжиж, биелсэн.

Төсөл нь АХБ-ны төслийн гүйцэтгэлийн хяналтын системд тогтмол “хэвийн хэрэгжилттэй” гэж үнэлэгдсэн.

2025 оны 8 дугаар сарын 29-ний байдлаар төслийн явц 99.6 хувьтай үнэлэгдсэн.

Үе шат	Хүрэх үр дүн
<p>Гаралт 1: Ядуу өрхөд чиглэсэн хүүхдийн мөнгөний нэмэгдэл олгосон.</p>	<p>Энэхүү гаралтын гүйцэтгэлийн үзүүлэлт нь: 2021 оны 1 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл 12 сарын хугацаанд хүүхдийн мөнгийг сар бүр 100,000 төгрөг болгон нэмэгдүүлэх. Энэхүү гаралт нь бүрэн хэрэгжиж, 2021 оны 1–6 дугаар сар болон 12 дугаар сард, нийт 7 сарын хугацаанд хүүхдийн мөнгийг сар бүр 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн үзүүлэлтийг хангасан. Хүүхдийн нийт тоо 2021 оны 1 дүгээр сард 1,190,283 байснаас 6 дугаар сард 1,208,411 хүүхэд, 12 дугаар сард 1,220,158 хүүхэд болж өссөн нь 2020 оны 11 дүгээр сарын суурь үзүүлэлт болох 1,184,158 -аас 3.04 хувиар өссөн байна. Дунджаар охид нийт хүүхдийн 48.9 хувийг эзэлсэн. Эдгээр үр дүн нь Төслийн зорилго, үр дүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэрэгжилтийг хянах системийн үр дүнгийн үзүүлэлт болон Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөний “дор хаяж 1.2 сая хүүхэд, үүний 48.2 хувь нь охид байх” зорилтыг давж биелүүлсэн. Гаралт 1-ийн хүрээнд нийт 66.78 сая ам.долларын гэрээ байгуулж, санхүүжилт хийсэн бөгөөд энэ нь нийт хуваарилагдсан 68.1 сая ам.долларын дүнгээс бүрдэнэ.</p>
<p>Гаралт 2: Нийгмийн хамгааллын хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>Ядуу болон эмзэг өрхийг илүү оновчтой тодорхойлохын тулд ядуурлын зорилтот систем болон “Өрхийн нэгдсэн мэдээллийн сан”-г шинэчлэх: Дор хаяж 26,900 өрхийн “Орлогыг орлуулан тооцох аргаар” мэдээллийг шинэ аргачлалаар өрхийн айлчлалаар баталгаажуулж, нас, хүйс, байршлаар ангилсан бөгөөд энэхүү үзүүлэлт бүрэн биелсэн. Төслийн дэмжлэгтэйгээр 2023 оны 5–6 дугаар сард батлагдсан “Орлогыг орлуулан тооцох арга” аргачлалаар улсын хэмжээний өрхийн дахин баталгаажуулалтын судалгааг хийсэн. Төсөл нь мэдээллийг баталгаажуулах, засварлах, шинэчилсэн мэдээллийн санд нэгтгэхэд дэмжлэг үзүүлсэн. 2023 оны 6 сараас 2024 оны 3 сар хүртэл 135,831 хүний мэдээллийг цэвэрлэж “Өрхийн нэгдсэн мэдээллийн сан” -д оруулсан бөгөөд өрхийн оноог шинэ “Орлогыг орлуулан тооцох арга” аргачлалаар тооцоолсон. 26,900 өрхийг дахин баталгаажуулах зорилт биелсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар өөрийн нөөцөөр нэмэлт өрхүүдийг хамруулж, өсөн байгууллагын мэдээллийг ашиглан “Орлогыг орлуулан тооцох арга”-г шинэчилсэн. Төсөл нь: Сервер шинэчлэх (G003) 240 ширээний компьютер, 132 зөөврийн компьютер 131 сканнер Сүлжээ болон бусад тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мөн 009 болон 011 гэрээтэй хоёр IT зөвлөх 2025 оны 8 дугаар сарын 31 хүртэл ажилласан.</p> <p>(ii) Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг “e-halamj” системд холбож, тэтгэмж болон үйлчилгээний хүргэлтийг оновчтой болгох зорилгоор цахимжуулалтыг дэмжих: Энэхүү үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт нь “e-halamj” системд дор хаяж 14 нэмэлт нийгмийн хамгааллын хөтөлбөр холбогдсон байх.</p>

	<p>Энэхүү зорилт биелсэн бөгөөд төслийн дэмжлэгтэйгээр 72 нийгмийн халамжийн үйлчилгээнээс 64 нь төрийн нэгдсэн “e-halamj” системд холбогдсон.</p> <p>“e-halamj” системийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (төрийн өмчит байгууллага) боловсруулсан бөгөөд “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” нь системийн хөгжүүлэлт, удирдлага болон мэдээллийн сангийн менежментэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Систем хөгжүүлэлт, техник хангамжийн удирдлага, мэдээллийн сангийн менежмент зэрэг техникийн дэмжлэг үзүүлэхээр сонгогдсон дөрвөн IT зөвлөхийн гэрээ 2024 оны 6 дугаар сарын 30-нд (нэг нь 2023 оны 9 дүгээр сарын 30-нд) дууссан.</p> <p>Сүлжээний хяналтын программ хангамж болон “e-halamj” системийн лиценз худалдан авах, мөн “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар” -д зориулсан техник хэрэгсэл худалдан авах ажиллагааг төсвийн хязгаарлалтын улмаас эхлүүлсэн боловч цуцалсан.</p> <p>Төсөл нь BIS системийг (Мэдээллийг шинжилж, тайлан гаргаж, шийдвэр гаргахад тусалдаг систем) шинэчлэх, “e-halamj” зэрэг шинэ системүүдтэй уялдуулах, системийн тогтвортой байдлыг хангах, техникийн асуудлыг шийдвэрлэх, хэрэглэгчийн саналд тулгуурлан функц сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>BIS системийн засвар үйлчилгээний дэмжлэг үзүүлж байсан C007 болон C008 гэрээтэй хоёр IT зөвлөхийн хувьд программын лиценз шинэчлэхэд тус бүр хоёр хүн-сарын ажил үлдсэн байсан.</p> <p>Гэвч төсвийн хязгаарлалтын улмаас лиценз худалдан авах ажиллагаа цуцлагдсан тул эдгээр зөвлөхүүдийн гэрээг мөн дуусгавар болгосон.</p> <p><b>(iii) Мөнгөн шилжүүлэг дээр суурилж, амьжиргааг дэмжих болон зөвлөх үйлчилгээний цогц арга хэмжээг хослуулсан, нийгмийн хамгааллын шинэлэг хөтөлбөр болох graduation аргачлалыг (Ядуу өрхүүдийг үе шаттайгаар дэмжиж, өөрийгөө авч явах чадвартай болгох цогц аргачлал) турших болон үнэлэх.</b></p> <p>Энэхүү үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт нь: Ядуу өрхийн хөдөлмөрийн насны дор хаяж 1,500 хүн (үүний 50 хувь нь эмэгтэй) орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэхэд чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээ бүхий graduation хөтөлбөрийн хөрөнгийн багцыг хүртсэн байх.</p> <p>Энэхүү үйл ажиллагаатай холбоотой төслийн үр дүнгийн үзүүлэлт нь: Graduation туршилтын хөтөлбөрт хамрагдсан өрхийн дор хаяж 80 хувь (үүний 50 хувь нь эмэгтэй) нь хөтөлбөрийн хүрээнд тогтоосон шалгуур үзүүлэлтээр хэмжигдсэнээр амьжиргаагаа сайжруулсан байх.</p> <p>2025 оны 4 дүгээр сарын байдлаар:</p> <ul style="list-style-type: none"><li>• 1,520 өрхөөс 1,259 (83%) оролцсон</li><li>• 7,402 хүн хамрагдсан</li></ul> <p>Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"><li>• 72.8% нь эмэгтэй оролцогч</li><li>• 37.7% нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх</li><li>• 10.8% нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй</li></ul> <p>Өрхүүд хүнсний үйлдвэрлэл, ногоо тариалалт зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.</p> <p>Ойролцоогоор 1,550 хөдөлмөрийн насны хүн хамрагдсан.</p> <p>Ахиц дэвшлийг улирал тутам цахим хяналтын системээр үнэлсэн.</p>
--	---

	2025 оны 1–3 дугаар сарын эцсийн үнэлгээгээр: <ul style="list-style-type: none"><li>84.5% өрх 10 үзүүлэлтээс 80%-аас дээш гүйцэтгэлд хүрсэн</li></ul> Үр дүнгийн зорилт биелсэн.
--	--

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Билгүүн, аудитор Ө.Батчимэг, Г.Уранзул нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Р.Энх-Амгалан, захирал Ч.Энхтуяа нар анхан шатны хяналтыг, Үндэсний Аудитын Газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Аудитын Газар-т 2026 оны 01 дугаар сарын 16-ны өдөр 26/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,820,354.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 38,203.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор аудитаар төлөвлөгдсөн нийт 76 заалтаас тус төслийн үйл ажиллагаанд хамааралтай 29 заалтыг түүвэрлэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зүйл заалтыг шалгуур үзүүлэлтээр авч үүнд тохирсон горим сорилыг хэрэгжүүлэхэд материаллагаар нөлөөлөх зөрчил гараагүй болно

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжээс шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 27 төрлийн 170 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроохгүй байх 1 албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,304,047.3	1	1,304,047.3	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,304,047.3</b>	<b>2</b>	<b>1,304,047.3</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус төсөл нь 2025 оны 08 дугаар сарын 31-нээр дуусгавар болж хаалтын тайлан байсан боловч өнөөдрийг хүртэл гараагүй байна. Тиймээс дараах асуудлыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

- Төслийн баримт бичиг, тайлан зэрэг материалуудыг архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;
- Төслийн хаалтын тайлангуудыг нэгтгэн Гэр бүл, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яаманд ирүүлэх;
- Хувь зөвлөхүүдийн үлдэгдэл санхүүжилтийг олгох, боловсруулсан ажлын тайланг авч үзэх;

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.